    <double>14</double>
  </test>
  <edit mode="assign" name="antialias">
    <bool>false</bool>
  </edit>
</match>
```



Жигд зай авалттай үсгийн маяганд *anti-aliasing* шинж чанар зөв хэрэгжихгүй байж магадгүй. Энэ асуудал **KDE** дээр их тулгардаг. Үүний засах нэг арга бол тийм үсгүүдийн зай авалтыг 100 байх ёстой гэж зааж өгдөг. Дараах мөрийг нэмж үүнийг гүйцэтгэнэ:

```
<match target="pattern" name="family">
  <test qual="any" name="family">
    <string>fixed</string>
  </test>
  <edit name="family" mode="assign">
    <string>mono</string>
  </edit>
</match>
<match target="pattern" name="family">
  <test qual="any" name="family">
    <string>console</string>
  </test>
  <edit name="family" mode="assign">
    <string>mono</string>
  </edit>
</match>
```

(энэ нь бусад ердийн ижил зай авалттай үсгийн маягуудыг "mono" гэсэн нэрээр хандана гэж зааж өгч байна) тэгээд дараа нь:

```
<match target="pattern" name="family">
  <test qual="any" name="family">
    <string>mono</string>
  </test>
  <edit name="spacing" mode="assign">
    <int>100</int>
  </edit>
</match>
```

**Helvetica** зэрэг зарим үсгийн маягуудад *anti-aliased* хэрэглэх үед бага зэрэг хүндрэлүүд гарч болзошгүй. Энэ загвар нь тийм үсгийн маягуудын талыг нь хасах шинж илэрдэг. Бүр таарахгүй муудах үед **Mozilla** зэргийн програмууд ажиллах үедээ нурдаг. Үүнээс сэргийлэхийн тулд `local.conf` файлд дараах мөрийг нэмнэ:

```
<match target="pattern" name="family">
  <test qual="any" name="family">
    <string>Helvetica</string>
  </test>
  <edit name="family" mode="assign">
    <string>sans-serif</string>
  </edit>
</match>
```

`local.conf` файлыг засварлаж дуусаад уг файлыг `</fontconfig>` таглаагаар дууссан эсэхийг шалгаарай. Ингээгүй бол уг файлын өөрчлөлтийг үл хэрэгсэж хэрэгжүүлдэггүй.

X11-тэй анх ирдэг үсгийн маягуудад *anti-aliasing* хэрэглэхэд тийм аятайхан харагддаггүй. Арай илүү анхдагч үсгийн маягийг `x11-fonts/bitstream-vera` портоос суулгаж болно. Энэ порт нь суугдах үедээ хэрэв `/usr/local/etc/fonts/local.conf` файл байхгүй бол мөн суулгадаг. Хэрэв файл өмнө нь

байвал энэ порт `/usr/local/etc/fonts/local.conf-vera` гэсэн файл үүсгэдэг. Үүний дотор байгааг `/usr/local/etc/fonts/local.conf` файл уруу нийлүүлбэл **Bitstream** үсгийн маягтууд автоматаар **X11 Serif, Sans Serif, болон Monospaced** үсгийн маягтуудын оронд сууж анхдагч үсгийн маяг нь болдог.

Эцэст нь хэрэглэгчид өөрсдийн гэсэн тохируулгаа хувийн сан дотор буй `.fonts.conf` файл дотор хийж болдог. Ингэхийн тулд хэрэглэгч бүр `~/.fonts.conf` файл үүсгэх хэрэгтэй. Энэ файл нь мөн **XML** хэлбэртэй байх ёстой.

Сүүлчийн үг: **LCD** дэлгэцтэй үед **sub-pixel** харуулалт хэрэглэх хүсэлт гарч болзошгүй. Энэ нь үндсэндээ (хэвтээ чиглэлд нь салгасан) улаан, ногоон болон цэнхэр өнгийн бүрдлүүдийг тусад нь салгаж харуулснаар хэвтээ чиглэлийн дүрслэх чадварыг сайжруулдаг. Үр дүн нь мэдээж маш сайн харуулалт үүсдэг. Ингэж зөвшөөрүүлэхийн тулд `local.conf` файлд дараах мөрийг нэмнэ:

```
<match target="font">
  <test qual="all" name="rgba">
    <const>unknown</const>
  </test>
  <edit name="rgba" mode="assign">
    <const>rgb</const>
  </edit>
</match>
```

**Note:** Дэлгэцийн төрлөөс хамаарч `rgb` нь `bgr`, `vrgb` эсвэл `vbgr` гэж өөрчлөгдөж болзошгүй тул янз янзаар нь туршиж аль нь илүү тохирч байгааг олоорой.

Дараагийн удаа **X**-г эхлэх үед **Anti-aliasing** зөвшөөрөгдсөн байх болно. Гэхдээ програмууд энэ шинж чанарын давуу талыг ашиглах хэрэгтэй. Одоогийн байдлаар **Qt** хэрэгсэл үүнийг ашигладаг. Энэ нь **KDE** орчны бүх үсгийн маягт **anti-aliased** хэрэгжүүлдэг. Мөн **GTK+** үүнийг ашиглан **GNOME** дээр “Font” програмаар (Section 5.7.1.3 дээр дэлгэрэнгүй мэдээлэл буй) үсгийн маягтдаа **anti-aliasing** хэрэгжүүлдэг. Анхныхаа тохиргоогоор **Mozilla 1.2** болон түүнээс дээшхи хувилбарууд нь автоматаар **anti-aliasing**-г ашигладаг. Үүнийг хорихын тулд **Mozilla**-г `-DWITHOUT_XFT` гэсэн сонголттой хөрвүүлж бэлдэх хэрэгтэй.

## 5.6 X Display Manager буюу харуулалт зохицуулагч

*Хамтран бичилцсэн Сэф Кингсли.*

### 5.6.1 Ерөнхий ойлголт

**X Display Manager (XDM)** буюу **X** харуулалт зохицуулагч гэдэг нь **X** цонхот системд сонгогдон хэрэглэгдэж болох бөгөөд нэвтрэх үйлдэлд хэрэглэгддэг. Энэ нь бага хүчин чадалтай “**X терминал**”, ширээний програмын орчин, мөн том сүлжээнд буй харуулалтын сервер зэрэг төрөл бүрийн нөхцөлд хэрэглэгддэг. Нэгэнт **X** цонхот систем нь сүлжээ болон бүртгэлийн бие даасан гүйцэтгэлтэй болохоор **X** үйлчлүүлэгч болон серверүүдийн хоорондох холбоог тохируулах маш олон арга бий. **XDM** нь холбогдож болох серверүүдийг график горимд дүрсэлж харуулдаг бөгөөд нэр болон нууц үг оруулах нөхцөл биелүүлж өгдөг.

Та **XDM**-г хэрэглэгчид зориулж `getty(8)` хэрэгслийн биелүүлдэг гүйцэтгэлтэй ( **Section 26.3.2** хэсгээс дэлгэрэнгүйг харна уу) ижил гэж бодох хэрэгтэй. Тэгэхээр энэ нь систем рүү нэвтрэх үйлдлийг гүйцэтгэдэг бөгөөд нэвтрүүлэхдээ тухайн хэрэглэгчийн орчинг ажиллуулж (голдуу X цонхны зохицуулагч байдаг ) хэрэглэгчийг гарах хүртэл нь хүлээж байдаг. Мөн өөр хэрэглэгч холбогдох үед холбогдох дэлгэцийг харуулан нэвтрэх үйлдэл хийлгэх боломжийг **XDM** биелүүлж байдаг.

## 5.6.2 XDM-г хэрэглэх нь

**XDM** далд чөтгөр гуай `/usr/local/bin/xdm` гэсэн байрлалд байдаг. Энэ нь `root` эрхтэй хүнээр ямар ч үед эхлүүлэгдэж болдог бөгөөд эхлэнгүүтээ уг машинд буй X цонхыг зохицуулах үүргийг гүйцэтгэж эхэлдэг. Хэрэв **XDM**-г машиныг шинээр ачаалагдах болгонд эхлүүлэх хүсэлтэй байгаа бол үүнийг биелүүлэх хамгийн эвтэйхэн зам бол `/etc/ttys` файлд оруулга хийж өгөх билээ. Энэ файлын зохион байгуулалтын талаар **Section 26.3.2.1** хэсэгт хараарай. `/etc/ttys` файл дотор **XDM**-г виртуал терминал дээр далд чөтгөр хэлбэрээр ажиллуулна гэсэн дараах мөр байдаг:

```
ttv8      "/usr/local/bin/xdm -nodaemon"  xterm    off secure
```

Анхдагч тохируулгаараа энэ нь хоригдсон байдаг бөгөөд идэвхжүүлэхийг хүсвэл тав дахь үг болох `off` гэснийг `on` болгож өөрчлөөд `init(8)`-г **Section 26.3.2.2** дээр заасны дагуу шинээр ачаалах хэрэгтэй. Эхний талбар нь уг програмын зохицуулах терминалын нэр бөгөөд `ttv8` гэсэн буй. Энэ нь **XDM** есдүгээр виртуал терминал дээр ажиллаж эхэлнэ гэсэн үг юм.

## 5.6.3 XDM-г тохируулах нь

**XDM**-г тохируулах файл `/usr/local/lib/X11/xdm` санд байдаг. Энэ сан дотор **XDM**-н харагдцыг өөрчилж тохируулах хэд хэдэн файл бий. Голдуу дараах төрлийн файлууд байдаг:

Файл	Тодорхойлолт
<code>Xaccess</code>	Хэрэглэгчийн эрхийн дүрэм.
<code>Xresources</code>	X-н <code>resource</code> буюу эх сурвалж анхдагч утгууд.
<code>Xservers</code>	Дотоод юм уу алсад буй холбогдож болох дэлгэц зохицуулагчдын жагсаалт.
<code>Xsession</code>	Нэвтрэх үед тухайн орчинд үйлдэгддэг анхдагч скрипт.
<code>Xsetup_*</code>	Нэвтрэх үйлдлээс өмнө нь програмуудыг ачаалагч скрипт.
<code>xdm-config</code>	Уг машин дээр ажиллаж байгаа бүх харуулагчдыг ерөнхийд нь тохируулагч файл.
<code>xdm-errors</code>	Сервер програмаас үүсгэгдсэн алдаанууд.
<code>xdm-pid</code>	Одоогийн ажиллаж байгаа <b>XDM</b> -н процесс ID дугаар.

Мөн энэ сан дотор **XDM**-г ажиллаж байх үед уг график орчныг тохируулдаг скрипт болон програмууд байдаг. Саяны жагсаасан файлуудын зориулалтыг ерөнхийд нь дор дурдав. Уг файлуудыг хэрэглэх дэлгэрэнгүй заавар нь `xdm(1)` хуудсанд тодорхойлогдсон байгаа.

Анхныхаа тохируулгаар бол энгийн нэгэн нэвтрэх дөрвөлжин цонх дотор уг машины нэр харуулагдсан байдаг ба том үсгээр “Login:” гэж бичээд доод хэсэгт нь “Password:” гэж нууц үг оруулах талбар байдаг. Энэ цонхноос эхлэн **XDM**-н харагдцыг өөрчилж эхэлж болох юм.

### 5.6.3.1 Xaccess

**XDM**-ээр хянагддаг харуулагчтай холбогдох протоколыг X Display Manager Connection Protocol (**XDMCP**) гэж нэрлэдэг. Энэ файл нь алсад буй компьютераас **XDMCP** холболт ямар дүрмээр хийгдэхийг заан хянаж байдаг. Энэ нь алсаас холбогдох холболтыг хүлээж авах тохиргоог `xdm-config` файлд хийх хүртэл хориотой байдаг. Анхдагч тохиргоогоороо бол ямар ч хэрэглэгчийн холболтыг зөвшөөрөхгүй гэж заагдсан байдаг.

### 5.6.3.2 Xresources

Энэ нь харуулагчдыг сонгох нэвтрэх дэлгэцийн харуулалтыг өөрчилж болох анхдагч утгууд хадгалсан файл юм. Энэ файлаар нэвтрэх програмыг өөрчилж болно. Файлын зохион байгуулалт нь **X11**-н бичиг баримтад заасантай ижил загвартай байдаг.

### 5.6.3.3 Xservers

Энэ нь сонгогдож болох харуулагчдын жагсаалт хадгалсан файл.

### 5.6.3.4 Xsession

Энэ файл нь **XDM**-д зориулсан хэрэглээг холбогдсоны дараа гүйцэтгэгдэх скрипт файл юм. Ихэнхдээ хэрэглэгчид өөрсдийнхөө эхлэл санд буй `~/ .xsession` файл дотор өөрсдийн гэсэн ажиллуулах бичлэгээ бичиж энэ файлын гүйцэтгэлийг дардаг.

### 5.6.3.5 Xsetup\_\*

Энэ файл нь нэвтрэх цонх болон харуулагчдыг сонгогдохоос өмнө автоматаар ажилладаг. Харуулагч болгонд зориулсан скрипт нь `Xsetup_` нэрэн дээр харуулагчийн дугаар залгагдсан нэртэй байдаг (жишээ нь дотоод харуулагч `Xsetup_0` гэсэн нэртэй байдаг). Энэ файлд голдуу `xconsole` зэргийн нэг юм уу хоёр програмыг ар талд ажиллуулж байхаар бичсэн байдаг.

### 5.6.3.6 xdm-config

Энэ файлд харуулагч болгонд хэрэглэгдэх програмын анхдагч утга хэлбэрийн тохируулгууд байдаг.

### 5.6.3.7 xdm-errors

Энэ файл дотор **XDM**-н ажиллуулахыг оролдсон серверээс гарсан алдаануудыг бичсэн байдаг. Хэрэв **XDM**-н эхлүүлсэн дэлгэц ямар нэгэн замаар гацах юм бол юунаас болсон эсэхийг нь мэдэх хамгийн зөв газар бол энэ билээ. Эдгээр алдаанууд мөн хэрэглэгчийн тухайн орчноос хамаарч `~/ .xsession-errors` файл дотор бас бичигддэг.

## 5.6.4 Сүлжээний харуулагч серверийг ажиллуулах

Бусад хэрэглэгчдийг харуулагч сервер рүү холбохын тулд та хандах эрхийн дүрмийг засварлаж холболт хүлээж авагчийг зөвшөөрүүлэх хэрэгтэй. Анхдагч утгаараа үүнийг хорьсон байдаг. **XDM**-г холболт хүлээж авдаг болгохын тулд эхлээд `xdm-config` файл доторх мөрийг тайлбар мөр болгож хүчингүй болгох хэрэгтэй:

```
! SECURITY: do not listen for XDMCP or Chooser requests
! Comment out this line if you want to manage X terminals with xdm
DisplayManager.requestPort: 0
```

тэгээд **XDM**-ийг шинээр эхлүүлэх хэрэгтэй. Ийм файлд “#” тэмдгээр тайлбар мэт болгож хасдаггүй харин “!” тэмдэг хэрэглэх хэрэгтэй гэдгийг санах хэрэгтэй. `Access` файл доторхоос жишээнүүдийг харах хэрэгтэй бөгөөд `xdm(1)` гарын авлагаас дэлгэрэнгүй унших нь зүйтэй.

## 5.6.5 XDM-н орлуулгууд

**XDM**-г орлох хэд хэдэн програм бий. Тэдний нэг болох **kdm**-г ( **KDE**-тэй цуг ирдэг) энэ бүлэгт тайлбарлах болно. Харуулалт зохицуулагч **kdm** нь маш олон төрлийн харуулах загварыг санал болгодог бөгөөд нэвтрэх үед цонх зохицуулагчдыг давхар сонгож болох боломж өгдөг.

## 5.7 Дэлгэцийн орчин

*Хамтран бичсэн Валентино Вашетто.*

Энэ хэсэгт FreeBSD-н X-д зориулсан төрөл бүрийн дэлгэцийн орчнуудыг тайлбарлах болно.

“Дэлгэцийн орчин” гэдэгт энгийн цонх зохицуулагчаас авахуулаад төрөл бүрийн ширээний програмыг агуулсан цогц програмууд болох **KDE** болон **GNOME** зэрэг ордог.

### 5.7.1 GNOME

#### 5.7.1.1 GNOME-н тухай

**GNOME** гэдэг нь компьютераа тохируулахад тань амарчилж хөнгөвчилсөн дэлгэцийн програмын орчин юм. **GNOME** дотор самбар (програм эхлүүлэх болон төлөв байдлыг нь харуулах зорилготой), дэлгэцийн орон зай (програмууд байрлахад зориулагдсан), дэлгэцийн хэрэгслүүд болон програмуудын цуглуулга, мөн програмууд өөр хоорондоо зохицож ажиллахад зориулагдсан хэд хэдэн журам агуулагдаж байдаг. Өөр үйлдлийн систем юм уу эсвэл өөр орчинд ажиллаж сурсан хүмүүст **GNOME**-н санал болгож байгаа хүчтэй бөгөөд аятайхан график орчин нь дасахад амар санагддаг. FreeBSD дээрх **GNOME**-н талаар дэлгэрэнгүй мэдээллийг FreeBSD-н GNOME Төслийн (<http://www.FreeBSD.org/gnome>) вэб хуудаснаас харах хэрэгтэй. Уг вэб хуудсанд **GNOME**-г хэрхэн суулгаж тохируулан мөн зохицуулах талаар нэлээн өргөн хэмжээний асуулт хариултууд байдаг.

#### 5.7.1.2 GNOME-г суулгах

Энэ програм хангамжийг портын цуглуулга юм уу эсвэл багцаас хялбар аргаар суулгаж болно:

Сүлжээнээс **GNOME**-г багц хэлбэрээр нь суулгахыг хүсвэл дараах тушаалыг өгөхөд хангалттай:

```
# pkg_add -r gnome2
```

**GNOME**-г порт дотор эх бичлэгээс нь хөрвүүлж суулгахыг хүсвэл дараах тушаалаар суулгана:

```
# cd /usr/ports/x11/gnome2
# make install clean
```

**GNOME** суугдсаны дараа X серверт анхдагч цонх зохицуулагчийн оронд **GNOME** эхлэхийг зааж өгөх хэрэг гардаг.

**GNOME**-г эхлүүлэх амархан арга бол **GNOME**-н харуулалтыг зохицуулагч буюу **GDM**-г хэрэглэх билээ. **GDM** нь **GNOME**-той хамт суугддаг (гэхдээ анхдагч тохиргоогоороо бол хоригдсон байдаг) бөгөөд `/etc/rc.conf` файл дотор `gdm_enable="YES"` мөрийг нэмэн оруулснаар идэвхжүүлдэг. Шинээр ачаалагдах үед нэвтрэлт хийсний дараа нэмэлт тохируулга хийлгүйгээр **GNOME** автоматаар эхэлдэг.

**GNOME**-г мөн тушаал бичдэг мөрнөөс `.xinitrc` файлд зөв тохируулга хийснээр ажиллуулж бас болно. Хэрэв `.xinitrc` файл өмнө нь байж байвал уг файлд байгаа цонх зохицуулагч эхлэх мөрийг арилгаад оронд нь `/usr/local/bin/gnome-session` гэж оруулах хэрэгтэй. Хэрэв нэг их онц чухал мөр уг тохиргооны файл дотор байхгүй гэж та мэдэж байгаа бол дараах тушаалыг өгч бас болно:

```
% echo "/usr/local/bin/gnome-session" > ~/.xinitrc
```

Тэгээд `startx` гэсэн тушаалыг бичихэд **GNOME** дэлгэцийн орчин эхлэх болно.

**Note:** Хэрэв **XDM** юм уу ямар нэгэн өөр дэлгэцийн орчин хэрэглэгдэж байсан бол `.xsession` гэсэн файл үүсгээд уг файл дотор өмнө ярьж байсан оруулгыг оруулах хэрэгтэй. Ингэхийн тулд уг файлыг засварлагчаар нээгээд дотор байгаа мөрийг `/usr/local/bin/gnome-session` мөрөөр дарж бичихэд болно:

```
% echo "#!/bin/sh" > ~/.xsession
% echo "/usr/local/bin/gnome-session" >> ~/.xsession
% chmod +x ~/.xsession
```

Өөр нэг сонголт бол цонх зохицуулагчид өөрчлөлт хийж нэвтрэлт хийгдэх үед дэлгэцийн орчныг сонгож болдгоор тохируулж болдог. **KDE**-н дэлгэрэнгүй хэсэгт **KDE**-н дэлгэцийн орчны зохицуулагч **kdm** дээр хэрхэн үүнийг хийдэг талаар тайлбарласан байгаа.

### 5.7.1.3 GNOME дээрх Anti-aliased үсгийн маягууд

X11 нь өөрийнхөө “RENDER” өргөтгөлийг ашиглан anti-aliased үсгийн маягийг харуулж байдаг. **GTK+** 2.0 болон түүнээс дээшхи хувилбар нь ( **GNOME**-д хэрэглэгддэг багаж хэрэгсэл) уг өргөтгөлийг ашиглаж чаддаг. anti-aliasing үсгийн маягийг тохируулах талаар Section 5.5.3 хэсэгт өгүүлсэн байгаа. Тэгэхээр програмаа шинэчилснээр **GNOME** орчинд anti-aliasing үсгийн маяг хэрэглэгдэж болно. Applications → Desktop Preferences → Font цэсийг сонгоод түүнээс Best shapes, Best contrast, эсвэл Subpixel smoothing (LCDs) гэдгийг сонгоход л боллоо. **GNOME**-д харъяалагддаггүй **GTK+** програмуудад бол ажиллуулахаасаа өмнө `GDK_USE_XFT` гэдэг орчны хувьсагчид 1 гэсэн утга өгөөд дараа нь уг програмыг ажиллуулбал болно.

## 5.7.2 KDE

### 5.7.2.1 KDE-н тухай

**KDE** бол хэрэглэхэд тун амар орчин үеийн дэлгэцийн орчин юм. Хэрэглэгчид хэрэгтэй **KDE**-н санал болгодог зарим зүйлс бол:

- Орчин үеийн сайхан дэлгэцийн орчин
- Сүлжээгээр ажиллуулахад ямар ч хүндрэлгүй
- **KDE** дэлгэцийн орчин болон түүний програмуудад зориулж өөртөө агуулсан тусламжийн системтэй
- **KDE**-н бүх програмууддаа тохирсон загвар маягтай
- Стандартчлагдсан цэс болон багажит самбар, гарын товчлолууд, өнгөний хүснэгт гэх мэтчилэн.
- Internationalization буюу олон хэлийн дэмжлэг: **KDE** нь 40 гаран гадаад хэл дээр боломжтой
- Бүх дэлгэцийн орчны тохируулгыг төвлөрүүлсэн цонхот загвартай тохиргоо хийх боломж
- Маш олон **KDE** програмууд

**KDE** нь **Konqueror** нэртэй UNIX ертөнцөд өрсөлдөөн ихтэй хөтлөгчүүдийн нэг болох вэб хөтлөгчтэй хамт ирдэг. **KDE**-н талаар дэлгэрэнгүй мэдээллийг **KDE** вэб хуудаснаас (<http://www.kde.org/>) харж болно. **KDE**-тэй холбоотой эх үүсвэрүүд болон **FreeBSD**-тэй холбоотой тусгай мэдээллийг **FreeBSD**-ийн баг дахь **KDE** (<http://freebsd.kde.org/>) вэб хуудаснаас лавлах хэрэгтэй.

**FreeBSD** дээр **KDE**-н хоёр хувилбар байдаг. Хувилбар 3 нь удаан хугацааны туршид байгаа бөгөөд маш тогтвортой хувилбар юм. Хувилбар 4 буюу дараа үеийн хувилбар нь портын цуглуулгад бас байдаг. Эдгээр нь бүр цуг зэрэгцэн суулгагдаж болдог.

### 5.7.2.2 KDE-г суулгах нь

**GNOME** болон бусад дэлгэцийн орчны програмуудыг суулгадаг шиг энэхүү програм хангамжийг портын цуглуулга юм уу эсвэл багцаас хялбар аргаар суулгаж болно:

Сүлжээгээр **KDE3**-г багц хэлбэрээр суулгана гэвэл дараах тушаалыг өгөхөд л болно:

```
# pkg_add -r kde
```

Сүлжээгээр **KDE4**-г багц хэлбэрээр суулгана гэвэл дараах тушаалыг өгөхөд л болно:

```
# pkg_add -r kde4
```

`pkg_add(1)` автоматаар уг програмын сүүлийн хувилбарыг нь нөхөж суулгах болно.

**KDE3**-г эх бичлэгээс нь хөрвүүлж суулгана гэвэл портын цуглуулгыг ашиглаарай:

```
# cd /usr/ports/x11/kde3
# make install clean
```

**KDE4**-г эх бичлэгээс нь хөрвүүлж суулгана гэвэл портын цуглуулгыг ашиглаарай:

```
# cd /usr/ports/x11/kde4
# make install clean
```

**KDE** суугдсаны дараа X серверт анхдагч цонх зохицуулагчийн оронд **KDE**-г ажиллуулна гэж зааж өгөх хэрэгтэй. Үүний тулд `.xinitrc` файлыг дараах аргаар засварлаж мөн болно:

**KDE3**-н хувьд:

```
% echo "exec startkde" > ~/.xinitrc
```

**KDE4**-н хувьд:

```
% echo "exec /usr/local/kde4/bin/startkde" > ~/.xinitrc
```

Одоо ингээд `startx` тушаалыг ажиллуулбал **KDE** дэлгэцийн орчин эхлэх болно.

Хэрэв урьд нь **XDM** зэрэг өөр дэлгэцийн орчин хэрэглэгдэж байсан бол тохируулга арай өөр байх болно. Тэр үед `.xsession` файлыг засварлах хэрэгтэй. Энэ бүлгийн сүүл хэсэгт **kdm**-н талаар зааварласан байгаа.

### 5.7.3 KDE-н талаар дэлгэрэнгүй

Одоо **KDE** суугдсан байгаа болохоор ихэнх зүйлсийг та тусламжийн системийг нь ашиглан нээж олох юм уу эсвэл зүгээр л цэснүүд дээр дарж туршиж болох юм. **Windows** эсвэл **Mac®** төрлийн хэрэглэгчдэд бол бараг гэртээ байгаа юм шиг л сэтгэгдэл төрөх байх.

**KDE**-н хамгийн сайн заавар бичиг баримтууд интернэт дээр бий. **KDE** өөртэйгөө хамт **Konqueror** хөтлөгч мөн маш олон програм болон өргөжүүлсэн бичиг баримтуудтай ирдэг. Бүлгийн үлдсэн хэсэгт санамсаргүй нээж олсон ч гэсэн сурахад хүндрэлтэй техникийн зарим асуудлуудыг зааварчлах болно.

#### 5.7.3.1 KDE Display Manager буюу KDE-н дэлгэцийн зохицуулагч

Олон хэрэглэгчтэй системийн администратор хэрэглэгчдэд график нэвтрэх горим хэрэглэхийг хүсдэг. Өмнө тайлбарласны дагуу **XDM** ийм зорилгоор бас хэрэглэгдэж болно. Гэхдээ **KDE** бас үүнтэй ижил үүрэг гүйцэтгэж чадах **kdm** нэртэй харагдац сайтай эвтэйхэн нэвтрэх хэсгийг санал болгодог. Мөн хэрэглэгч бүр уг зохицуулагчийн цэснээс ямар дэлгэцийн орчинд холбогдохоо (**KDE**, **GNOME**, эсвэл бусад өөр) нэвтрэх үедээ сонгож болдог.

**kdm**-г идэвхжүүлэхийн тулд `/etc/ttys` файлд буй `ttv8` гэсэн оруулгатай хэсэг дараах маягаар өөрчлөгдөх ёстой:

**KDE3**-н хувьд:

```
ttv8 "/usr/local/bin/kdm -nodaemon" xterm on secure
```

**KDE4**-н хувьд:

```
ttv8 "/usr/local/kde4/bin/kdm -nodaemon" xterm on secure
```



## 5.7.4 Xfce

### 5.7.4.1 Xfce-н тухай

**Xfce** нь **GNOME** дээр хэрэглэгддэг **GTK+** хэрэгсэл дээр үндэслэгдсэн дэлгэцийн орчин бөгөөд хэрэглэхэд маш хөнгөн амархан тохируулгатай билээ. Өнгөц харахад **UNIX** системүүд дээр байдаг үнэтэй зарагддаг **CDE** дэлгэцийн орчинтой төсөөтэй. **Xfce**-н зарим шинж чанарыг дурдвал:

- Дэлгэцийн орчинд ажиллахад тун амар хялбаршуулсан
- Хулганы чирж тавих үйлдэл зэрэгт бүрэн тохируулагдсан
- Цэс болон програм ачаалах үндсэн самбар нь **CDE**-тэй ижил
- Цонх зохицуулагч, файл зохицуулагч, дууны оролт гаралтыг зохицуулагч, **GNOME**-н дэмжлэгтэй програмуудыг ажиллуулах тохиромж зэрэг олон зүйлсийг багтаасан
- Орчноо өөрчилж болдог (**GTK+** дэмжлэгтэй учраас)
- Түргэн, хөнгөн үр бүтээлтэй болохоор санах ойн хязгаарлалтай удаан машинуудад тун тохиромжтой.

**Xfce**-н дэлгэрэнгүй мэдээллийг **Xfce** вэб хуудаснаас (<http://www.xfce.org/>) хараарай.

### 5.7.4.2 Xfce-г суулгах нь

**Xfce**-н багц хувилбар (үүнийг бичиж байх үед) байдаг. Суулгахын тулд ердөө л:

```
# pkg_add -r xfce4
```

Мөн портын цуглуулга дотроос эх бичлэгээс нь хөрвүүлж суулгаж болно:

```
# cd /usr/ports/x11-wm/xfce4
# make install clean
```

Одоо **X** серверт **X** орчныг эхлүүлэх үед **Xfce**-г ажиллуул гэж зааж өгөхийн тулд:

```
% echo "/usr/local/bin/startxfce4" > ~/.xinitrc
```

Дараагийн удаа **X** эхлэх үед **Xfce** нь дэлгэцийн орчин болсон байна. Мөн өмнөх орчнуудтай ижил, хэрэв **XDM** зэрэг өөр орчин урьд нь хэрэглэгдэж байсан бол `.xsession` файлыг үүсгээд **GNOME** хэсэгт тайлбарласан шиг гэхдээ `/usr/local/bin/startxfce4` гэсэн утгыг оруулах юм уу эсвэл нэвтрэх үед сонгогдохоор болгож тохируулахыг хүсвэл **kdm** хэсэгт тайлбарласны дагуу хийх хэрэгтэй.

## II. Нийтлэг асуудлууд

Үндсэн ойлголтуудыг нэгэнт тайлбарласан болохоор одоо FreeBSD-ийн гарын авлагын энэ хэсэгт FreeBSD-ийн зарим байнга ашиглагддаг боломжуудыг авч үзэх болно. Эдгээр бүлгүүд нь:

- Түгээмэл хэрэглэгддэг ширээний програмуудыг танд танилцуулах болно: хөтчүүд, бүтээмжийн багажууд, баримт үзэгчид гэх мэт.
- FreeBSD-н хэд хэдэн мультимедиа багажуудыг танд танилцуулах болно.
- Тусгайлан тохируулсан FreeBSD цөмийг бүтээх үйл явц болон, системд нэмэлт функцуудыг хэрхэн идэвхжүүлэхийг тайлбарлах болно.
- Ширээний болон сүлжээнд холбогдсон хэвлэгчийн тохируулгуудын хувьд хэвлэх системийг дэлгэрэнгүй тайлбарлах болно.
- FreeBSD систем дээр Линукс програмуудыг хэрхэн ажиллуулахыг танд үзүүлэх болно.

Эдгээр бүлгүүдийн заримд таныг зарим нэг ойлголтуудын талаар урьдаар уншихыг зөвлөх бөгөөд энэ нь бүлэг бүрийн эхэнд ерөнхий агуулгад дурдсан байгаа болно.

# Chapter 6 Ширээний програмууд

*Хувь нэмэр болгон оруулсан Кристоф Жунье. Орчуулсан Цагаанхүүгийн Ганболд.*

## 6.1 Ерөнхий агуулга

FreeBSD нь текст боловсруулагч програмууд болон хөтчүүд зэрэг ширээний төрөл бүрийн хэрэглээний програмуудыг ажиллуулж чаддаг. Эдгээр програмуудын ихэнх нь багц хэлбэрээр юм уу эсвэл портуудын цуглуулгаас автоматаар бүтээгдэж болно. Шинэ хэрэглэгчдийн олонхи нь эдгээр хэрэглээний програмуудыг өөрийн компьютер дээр суулгахыг хүсдэг. Энэ бүлэгт зарим нэг түгээмэл хэрэглэгддэг ширээний програмуудыг портуудын цуглуулга болон тэдгээрийн багцуудаас хүндрэлгүйгээр суулгах талаар зааварлах болно.

Портуудаас програмуудыг суулгахад тэдгээрийг эхээс эмхэтгэдэг гэдгийг анхаарна уу. Энэ нь таны машины (машинуудын) процесс хийх хүч болон юу эмхэтгэж байгаагаас хамаарч их удаан ажиллаж болох юм. Эхээс бүтээх нь саад болмоор их хугацаа шаардаж байвал та портын цуглуулгад байгаа ихэнх програмуудыг урьдчилан бүтээсэн багцуудаас суулгаж болно.

FreeBSD нь Линуксийн хоёртын хэлбэртэй нийцтэй ажиллах боломжийг хангадаг учраас Линуксд эхлэн хөгжүүлэгдсэн олон програмуудыг ашиглах боломжтой байдаг. Линуксийн ямар ч хэрэглээний програмыг суулгахаасаа өмнө Chapter 10-ийг уншихыг зөвлөж байна. Линуксийн хоёртын хэлбэртэй нийцтэй байдлыг ашиглаж байгаа ихэнх портуудын нэр “linux-” гэж эхэлсэн байгаа. Жишээ нь `whereis(1)` тусгаалын тусламжтайгаар ямар нэг портыг хайж байхдаа үүнийг санаарай. Нийтлэлийн энэ хэсгээс цааш ямар нэг Линуксийн хэрэглээний програмуудыг суулгахын өмнө таныг Линуксийн хоёртын хэлбэртэй нийцтэй байдлыг идэвхжүүлсэн байгаа гэж тооцох болно.

Энэ бүлэгт доорх хэсгүүдийн тухай ярих болно:

- Хөтчүүд (**Firefox**, **Opera**, **Konqueror** зэрэг)
- Бүтээмж ( **KOffice**, **AbiWord**, **The GIMP**, **OpenOffice.org** зэрэг)
- Бичиг баримт үзүүлэгчид (**Acrobat Reader®**, **gv**, **Xpdf**, **GQview** зэрэг)
- Санхүү ( **GnuCash**, **Gnumeric**, **Abacus** зэрэг)

Энэ бүлгийг уншихаасаа өмнө, та дараах зүйлсийг мэдэх шаардлагатай:

- Гуравдагч талуудын нэмэлт програмуудыг хэрхэн суулгах талаар мэдэх (Chapter 4).
- Линуксийн нэмэлт програм хангамжуудыг хэрхэн суулгах талаар мэдэх (Chapter 10).

Мультимедиа орчны тохиргооны тухай мэдээллийг Chapter 7-с уншина уу. Хэрэв та цахим захидал тохируулж ашиглахыг хүсвэл Chapter 28-т хандана уу.

## 6.2 Хөтчүүд

FreeBSD нь тодорхой хөтөч урьдчилан суулгагдсан байдаггүй. Харин портын цуглуулгын [www](http://www.FreeBSD.org/ports/www.html) (<http://www.FreeBSD.org/ports/www.html>) сан суулгахад бэлэн олон хөтчүүдийг агуулдаг. Танд бүгдийг эмхэтгэх хугацаа байхгүй бол (энэ нь зарим тохиолдолд маш их хугацаа шаардаж болно) тэдгээрийн олонхи нь багц хэлбэрээр байдаг.

**KDE** болон **GNOME** нь **HTML** хөтчүүдээр хангадаг. Эдгээр бүрэн гүйцэд ширээний програмуудыг хэрхэн суулгаж тохируулах талаар дэлгэрэнгүй мэдээллийг **Section 5.7**-с лавлана уу.

Хэрэв та хөнгөн чанарын хөтчүүдийг хайж байгаа бол портын цуглуулгаас `www/dillo2`, `www/links`, эсвэл `www/w3m` зэргүүдийг судалж үзэх хэрэгтэй.

Энэ хэсэг эдгээр програмуудыг авч үзэх болно:

Програмын нэр	Шаардлагатай эх үүсвэрүүд	Портоос суулгах	Гол хамаарлууд
<b>Firefox</b>	дунд зэрэг	хүнд	<b>Gtk+</b>
<b>Opera</b>	бага	хөнгөн	<b>FreeBSD</b> болон Линуксийн хувилбарууд байдаг. Линуксийн хувилбар нь Линуксийн хоёртын нийцтэй байдал болон <b>linux-openmotif</b> -с хамаардаг.
<b>Konqueror</b>	дунд зэрэг	хүнд	<b>KDE</b> сангууд

### 6.2.1 Firefox

**Firefox** нь **FreeBSD** рүү бүрэн порт хийгдсэн орчин үеийн, чөлөөтэй, нээлттэй эхийн тогтвортой хөтөч юм. Энэ нь стандартыг хангасан **HTML** үзүүлэх хэсэг, **tab** нээж ажиллах боломж, **popup** хаалт, өргөтгөлүүд, сайжруулсан аюулгүй байдал зэрэг олон боломжуудтай. **Firefox** нь **Mozilla**-ийн код дээр суурилжээ.

**Firefox** нь **Mozilla**-ийн код дээр суурилсан дараагийн үеийн хөтөч юм. **Mozilla** нь хөтөч, захидлын клиент, чалчих клиент зэрэг олон програмуудыг багтаасан бүрэн гүйцэд програмуудын цуглуулга юм. **Firefox** нь зөвхөн хөтөч бөгөөд энэ нь түүнийг илүү жижиг, хурдан болгодог байна.

Доор дурдсаныг бичин багцыг суулгана:

```
# pkg_add -r firefox
```

Энэ нь **Firefox 2.X**-ийг суулгах бөгөөд та хэрэв **Firefox 3.X**-ийг ашиглахыг хүсэж байвал доорхийг ажиллуулаарай:

```
# pkg_add -r firefox3
```

Эх кодоос эмхэтгэхийг та илүүд үзэж байгаа бол портын цуглуулгыг бас ашиглаж болох юм:

```
# cd /usr/ports/www/firefox
# make install clean
```

**Firefox 3.X**-ийн хувьд өмнөх тушаал дээрх **firefox**-ийг **firefox3**-аар солиорой.

## 6.2.2 Firefox болон Java™ залгаас (plugin)

**Note:** Энэ хэсэгт болон дараагийнхад бид таныг **Firefox**-г аль хэдийн суулгасан гэж тооцох болно.

FreeBSD Сан нь Sun Microsystems компанитай Java Runtime Environment (JRE™) буюу Жавагийн Ажиллах үеийн орчин болон Java Development Kit (JDK™) буюу Жавагийн Хөгжүүлэх хэрэгслийн хоёртын файлуудыг түгээх лицензтэй байдаг. FreeBSD-д зориулсан хоёртын багцууд нь FreeBSD Сан (<http://www.freebsdoundation.org/downloads/java.shtml>) вэб сайтад байдаг.

**Firefox**-д Java™ дэмжлэгийг нэмэхийн тулд та `java/javawrapper` портыг суулгах хэрэгтэй. Дараа нь <http://www.freebsdoundation.org/downloads/java.shtml> хаягаас **Diablo JRE** багцыг татан авч `pkg_add(1)` тушаалаар суулгах хэрэгтэй.

Өөрийн хөтчийг эхлүүлж байрлал оруулдаг мөрөнд `about:plugins` гэж бичин **Enter** дарна. Суулгагдсан залгаасуудын талаар хуудас үзүүлэгдэх бөгөөд **Java** залгаас тэнд одоо байх ёстой. Хэрэв тийм биш бол хэрэглэгч бүр дараах тушаалыг ажиллуулах шаардлагатай:

```
% ln -s /usr/local/diablo-jre1.6.0/plugin/i386/ns7/libjavaplugin_oji.so \
  $HOME/.mozilla/plugins/
```

Хэрэв та **Diablo JDK** багцыг суулгасан бол:

```
% ln -s /usr/local/diablo-jdk1.6.0/jre/plugin/i386/ns7/libjavaplugin_oji.so \
  $HOME/.mozilla/plugins/
```

Дараа нь өөрийн хөтчийг дахин дуудна.

## 6.2.3 Firefox болон Macromedia® Flash™ залгаас (plugin)

Macromedia® Flash™ залгаас нь FreeBSD-д байдаггүй. Гэхдээ залгаасын Линукс хувилбарыг ажиллуулах програм хангамжийн давхарга (гүйцэтгэл хялбаршуулагч) байдаг. Энэ хялбаршуулагч нь бас Adobe® Acrobat® залгаас, RealPlayer® залгаас болон өөр олныг дэмждэг.

Таны ашиглаж байгаа FreeBSD-ийн хувилбараас хамаараад төрөл бүрийн алхмууд шаардлагатай:

### 1. FreeBSD 7.X-ийн хувьд

`www/nspluginwrapper` порт суулгана. Уг порт нь `emulators/linux_base-fc4` портыг шаардах бөгөөд энэ нь том порт юм.

Дараагийн алхам нь `www/linux-flashplugin9` портыг суулгах явдал юм. Энэ нь Flash 9.X-ийг суулгана. Энэ хувилбар нь FreeBSD 7.X дээр зөв ажилладаг.

**Note:** FreeBSD 7.1-RELEASE-с хуучин FreeBSD дээр та `www/linux-flashplugin7`-г суулгаж доорх `linprocfs(5)` хэсгийг алгасах хэрэгтэй.

### 2. FreeBSD 8.X-ийн хувьд

`www/nspluginwrapper` порт суулгана. Уг порт нь `emulators/linux_base-f10` портыг шаардах бөгөөд энэ нь том порт юм.

Дараагийн алхам нь `www/linux-f10-flashplugin10` портыг суулгах явдал юм. Энэ нь Flash 10.X-ийг суулгана. Энэ хувилбар нь FreeBSD 8.X дээр зөв ажилладаг.

Энэ хувилбар нь дараах холбоосыг үүсгэхийг шаарддаг:

```
# ln -s /usr/local/lib/npapi/linux-f10-flashplugin/libflashplayer.so \
    /usr/local/lib/browser_plugins/
```

Таны ажиллуулж байгаа FreeBSD-ийн хувилбарт таарсан зөв Flash порт суулгагдсаны дараа залгаасыг хэрэглэгч бүрийн хувьд `nspluginwrapper` тушаал ашиглан суулгах шаардлагатай:

```
% nspluginwrapper -v -a -i
```

Хэрэв Flash хүүхэлдэйг тоглуулахыг хүсвэл Linux-ийн процесс файлын систем `linprocfs(5)`-ийг `/usr/compat/linux/proc` руу холбосон байх шаардлагатай. Үүнийг дараах тушаалыг ашиглан хийж болно:

```
# mount -t linprocfs linproc /usr/compat/linux/proc
```

Үүнийг ачаалах үед автоматжуулан `/etc/fstab` файлд тохирох мөрийг нэмэн хийж өгч болно:

```
linproc /usr/compat/linux/proc linprocfs rw 0 0
```

Тэгээд өөрийн хөтчийг эхлүүлж байрлал оруулдаг мөрөнд `about:plugins` гэж бичин **Enter** дарна. Байгаа бүх залгаасуудтай жагсаалт гарч ирэх ёстой.

## 6.2.4 Firefox болон Swfdec Flash залгаас

Swfdec нь Flash анимацыг задалж амилуулах сан юм. Swfdec-Mozilla нь SWF файлуудыг тоглуулахын тулд Swfdec санг ашигладаг бөгөөд **Firefox** хөтчид зориулагдсан залгаас юм. Энэ нь хүчтэй хөгжүүлэлтийн доор оршсон хэвээр байгаа болно.

Хэрэв та бүтээж чадахгүй эсвэл хүсэхгүй байгаа бол сүлжээнээс багцыг суулгаж болно:

```
# pkg_add -r swfdec-plugin
```

Хэрэв багц байхгүй бол та үүнийг портын цуглуулгаас бүтээн суулгаж болно:

```
# cd /usr/ports/www/swfdec-plugin
# make install clean
```

Дараа нь энэ залгаасыг идэвхжүүлэхийн тулд өөрийн хөтчийг дахин ажиллуулаарай.

## 6.2.5 Opera

**Opera** нь өргөн боломжуудтай стандартад нийцсэн хөтөч юм. Энэ нь өөртөө бүтээгдсэн захидал болон мэдээ уншигч, IRC клиент, RSS/Atom уншигч болон өөр олон боломжуудыг агуулдаг. Эдгээрээс гадна **Opera** нь харьцангуй хөнгөн бөгөөд маш хурдан юм. Энэ нь хоёр хэлбэрээр байдаг нь: “эх” FreeBSD хувилбар болон Линуксийн эмуляц дээр ажилладаг хувилбар юм.

**Opera**-ийн FreeBSD хувилбараар вэб үзэхийн тулд багцыг суулгана:

```
# pkg_add -r opera
```

Зарим нэг FTP сайтуудад бүх багцууд байдаггүй боловч портын цуглуулгыг ашиглан доор дурдсаныг бичин **Opera**-г авч болно:

```
# cd /usr/ports/www/opera
# make install clean
```

**Opera**-ийн Линукс хувилбарыг суулгахын тулд дээрх жишээний **opera** гэсний оронд **linux-opera** гэж солих хэрэгтэй. **Adobe Acrobat Reader** зэрэг зөвхөн Линуксд байдаг залгаасуудын хэрэглээг шаардах тохиолдолд Линуксийн хувилбар нь ашигтай байдаг. Бусад талаараа **FreeBSD** болон Линуксийн хувилбарууд нь ажиллагааны хувьд адилхан байдаг.

## 6.2.6 Konqueror

**Konqueror** нь **KDE**-ийн нэг хэсэг боловч үүнийг **KDE**-ийн гадна талд **x11/kdebase3**-ийг суулган бас ашиглаж болох юм. **Konqueror** ердийн нэг хөтчөөс илүү бөгөөд файлын менежер болон мультимедиа үзүүлэгч болж чаддаг.

**Konqueror** нь бас залгаасуудын олонлогтой ирдэг бөгөөд эдгээрийг **misc/konq-plugins** сангаас суулгах боломжтой байдаг.

**Konqueror** бас **Flash**-г дэмждэг бөгөөд **Konqueror** дээр **Flash**-ийн дэмжлэгтэй болох талаар “Хэрхэн Хийх” заавар нь <http://freebsd.kde.org/howtos/konqueror-flash.php> хаягт байдаг.

## 6.3 Бүтээмж

Бүтээмжтэй холбоотой болоод ирэхээрээ, шинэ хэрэглэгчид ихэвчлэн сайн оффисийн цуглуулга эсвэл нөхөрсөг текст боловсруулагчийг хайдаг. **KDE** зэрэг зарим ширээний орчнууд нь хэдийгээр оффисийн цуглуулгатай байдаг боловч анхдагч бүтээмжийн багц байдаггүй билээ. **FreeBSD** нь таны ширээний орчноос хамааралгүйгээр хэрэгтэй бүгдийг хангадаг.

Энэ хэсэг нь эдгээр програмуудыг авч үзэх болно:

Програмын нэр	Шаардлагатай эх үүсвэрүүд	Портоос суулгах	Гол хамаарлууд
<b>KOffice</b>	бага	хүнд	<b>KDE</b>
<b>AbiWord</b>	бага	хөнгөн	<b>Gtk+</b> эсвэл <b>GNOME</b>
<b>Gimp</b>	бага	хүнд	<b>Gtk+</b>
<b>OpenOffice.org</b>	их	асар их	<b>JDK 1.4, Mozilla</b>

### 6.3.1 KOffice

**KDE**-ийн хүрээнийхэн **KDE**-ээс гадна ашиглагдаж болох оффисийн цуглуулгатай өөрийн ширээний орчинг өгдөг. Энэ нь бусад оффисийн цуглуулгад байдаг дөрвөн стандарт бүрэлдэхүүнийг агуулдаг. **KWord** нь текст боловсруулагч, **KSpread** нь хүснэгттэй ажилладаг програм, **KPresenter** нь танилцуулгуудыг удирддаг бөгөөд **Kontour** нь график баримтуудыг зурахыг зөвшөөрнө.

Хамгийн сүүлчийн **KOffice**-г суулгахаасаа өмнө та **KDE**-ийн хамгийн шинэчлэгдсэн хувилбартай эсэхээ шалгаарай.

**KOffice**-ийг багц хэлбэрээр суулгахын тулд дараах тушаалыг ажиллуулна:

```
# pkg_add -r koffice
```

Хэрэв багц байхгүй бол та портын цуглуулгыг ашиглаж болно. Жишээ нь **KDE3**-д зориулж **KOffice**-г суулгахын тулд доор дурдсаныг ажиллуулна:

```
# cd /usr/ports/editors/koffice-kde3
# make install clean
```

### 6.3.2 AbiWord

**AbiWord** нь **Microsoft Word**-той төстэй харагдаж, санагддаг, чөлөөтэй, текст боловсруулагч програм юм. Энэ нь бичиг, захидал, тайлан, сануулга гэх зэргүүдийг бичихэд тохиромжтой юм. Энэ нь маш хурднаас гадна олон боломжуудыг агуулдаг бөгөөд хэрэглэгчид маш хялбар байдаг.

**AbiWord** нь Microsoft-ийн .doc зэрэг арилжааныхыг оруулаад олон файлын хэлбэршилтүүдийг импорт болон экспорт хийж чаддаг.

**AbiWord** нь багц хэлбэрээр байдаг. Та дараах тушаалыг ажиллуулан үүнийг суулгаж болно:

```
# pkg_add -r abiword
```

Хэрэв багц байхгүй бол үүнийг портын цуглуулгаас эмхэтгэж болно. Портын цуглуулга шинэчлэгдсэн байх ёстой. Үүнийг ингэж хийж болно:

```
# cd /usr/ports/editors/abiword
# make install clean
```

### 6.3.3 GIMP

Зургийг зохиох эсвэл дүрс тодруулах тохиолдолд **GIMP** нь маш нарийн, зурагтай ажиллах програм юм. Энэ нь энгийн будах програм эсвэл чанартай, фото зураг тодруулах цуглуулга болгон ашиглагдаж болох юм. Энэ нь олон тооны нэмэлт залгаасыг (plug-ins) дэмждэг бөгөөд скрипт хийх интерфэйсийн боломжуудтай байдаг. **GIMP** нь төрөл бүрийн файлын хэлбэршилтүүдийг уншиж, бичиж чаддаг. Энэ нь сканнер болон зөөврийн цахим төхөөрөмжтэй (tablet) холбогдох боломжийг дэмждэг.

Та энэ тушаалыг ажиллуулан багцыг суулгаж болно:

```
# pkg_add -r gimp
```

Хэрэв таны FTP сайт энэ багцгүй байгаа бол та портын цуглуулгыг ашиглаж болно. Портын цуглуулгын graphics (<http://www.FreeBSD.org/ports/graphics.html>) сан бас **Gimp Manual** програмыг агуулдаг. Энд тэдгээрийг хэрхэн суулгах талаар үзүүлэв:

```
# cd /usr/ports/graphics/gimp
# make install clean
# cd /usr/ports/graphics/gimp-manual-pdf
# make install clean
```



**Note:** Портын цуглуулгын `graphics` (<http://www.FreeBSD.org/ports/graphics.html>) сан **GIMP**-ийн хөгжүүлэлтийн хувилбарыг `graphics/gimp-devel` санд агуулдаг. **Gimp Manual**-ийн HTML хувилбар нь `graphics/gimp-manual-html` санд байдаг.

### 6.3.4 OpenOffice.org

**OpenOffice.org** нь бүх шаардлагатай програмуудыг бүрэн гүйцэд оффисийн бүтээмжийн цуглуулгадаа агуулсан байдаг: энд текст боловсруулагч, хүснэгттэй ажиллах програм, танилцуулгын менежер, болон зургийн програмыг дурдаж болно. Уг програмын хэрэглэгчийн интерфэйс нь бусад оффисийн цуглуулгуудтай их төстэй бөгөөд төрөл бүрийн файлын хэлбэршилтүүдийг импорт, экспорт хийж чаддаг байна. Энэ нь интерфэйсүүд, алдаа шалгагчид болон тольнуудыг оролцуулаад хэд хэдэн өөр хэлнүүд дээр байдаг.

**OpenOffice.org**-ийн текст боловсруулагч нь эх XML файлын хэлбэршилтийг зөөвөрлөгдөх боломж ба уян хатан чанарыг сайжруулах зорилгоор ашигладаг. Хүснэгттэй ажиллах програм нь макро хэлний боломжтой бөгөөд гаднах мэдээллийн баазуудтай холбогдох боломжтой байдаг. **OpenOffice.org** нь аль хэдийн тогтвортой болсон бөгөөд Windows, Solaris™, Линукс, FreeBSD, болон Mac OS X дээр ажилладаг. **OpenOffice.org**-ийн тухай илүү мэдээллийг OpenOffice.org вэб сайт (<http://www.openoffice.org/>) аас олж болно. FreeBSD-тэй холбоотой мэдээлэл болон багцуудыг шууд татаж авахын тулд FreeBSD OpenOffice.org Хөрвүүлэх Баг (<http://porting.openoffice.org/freebsd/>)-ийн вэб сайтыг ашиглана уу.

**OpenOffice.org**-ийг суулгахын тулд доор дурдсаныг ажиллуулна:

```
# pkg_add -r openoffice.org
```

**Note:** FreeBSD-ийн -RELEASE хувилбарыг ажиллуулж байхад энэ нь ажиллах ёстой. Үгүй бол та тохирох багцыг татан авч `pkg_add(1)` ашиглан суулгахын тулд FreeBSD-ийн **OpenOffice.org** Хөрвүүлэх Багийн вэб хаягт хандах хэрэгтэй. Одоогийн хувилбар болон хөгжүүлэлтийн хувилбар нь энд татаж авагдахаар байрладаг.

Багц суулгагдсаны дараа **OpenOffice.org**-ийг ажиллуулахын тулд та ердөө л дараах тушаалыг бичих хэрэгтэй:

```
% openoffice.org
```

**Note:** Эхний удаа ажиллуулахад танаас зарим нэг асуултууд асуух бөгөөд `.openoffice.org2` сан таны гэрийн санд үүсгэгдэх болно.

Хэрэв **OpenOffice.org** багцууд байхгүй бол портыг эмхэтгэх сонголт танд бас байдаг. Гэхдээ энэ нь дискний асар их зай болон эмхэтгэх хугацаа ихийг шаардана гэдгийг та санаж байх ёстой шүү.

```
# cd /usr/ports/editors/openoffice.org-2
# make install clean
```

**Note:** Хэрэв та локалчлагдсан хувилбарыг бүтээхийг хүсэж байгаа бол түрүүчийн тушаалын мөрийг дараах мөрөөр солих хэрэгтэй:

```
# make LOCALIZED_LANG=your_language install clean
```

Та *your\_language* мөрийг зөв хэлний ISO кодоор солих хэрэгтэй. Дэмжигдсэн хэлний кодуудын жагсаалт портын санд байх `files/Makefile.localized` файлд байдаг.

Үүнийг хийсний дараа **OpenOffice.org**-г дараах тушаалаар ажиллуулж болно:

```
% openoffice.org
```

## 6.4 Бичиг баримт үзүүлэгчид

Баримтын зарим нэгэн шинэ хэлбэршилтүүд UNIX-ийг бий болсон цагаас эхлэн түгээмэл болсон билээ. Тэдгээрийн шаарддаг стандарт үзүүлэгчид үндсэн системд байхгүй байж болох юм. Бид тэдгээр үзүүлэгчдийг хэрхэн суулгахыг энэ хэсэгт үзэх болно.

Энэ хэсэг нь эдгээр програмуудыг авч үзэх болно:

Програмын нэр	Шаардлагатай эх үүсвэрүүд	Портоос суулгах	Гол хамаарлууд
<b>Acrobat Reader</b>	бага	хөнгөн	Линуксийн хоёртын хэлбэртэй нийцтэй байдал
<b>gv</b>	бага	хөнгөн	<b>Xaw3d</b>
<b>Xpdf</b>	бага	хөнгөн	<b>FreeType</b>
<b>GQview</b>	бага	хөнгөн	<b>Gtk+</b> эсвэл <b>GNOME</b>

### 6.4.1 Acrobat Reader®

Олон баримтууд нь одоо PDF файл хэлбэрээр тараагддаг бөгөөд энэ нь “Portable Document Format” буюу зөөврийн баримтын хэлбэршилт гэгддэг. Эдгээр файлуудын төрлүүдэд зориулсан, зөвлөдөг үзүүлэгчдийн нэг нь Adobe-оос гаргасан Линуксд зориулсан **Acrobat Reader** юм. FreeBSD нь Линуксийн хоёртын хэлбэрийн програмуудыг ажиллуулж чаддаг болохоор энэ нь FreeBSD-д бас байдаг юм.

Портын цуглуулгаас **Acrobat Reader 7**-г суулгахын тулд доор дурдсаныг хийнэ:

```
# cd /usr/ports/print/acroread7
# make install clean
```

Лицензийн хязгаарлалтуудаас болоод багц байдаггүй.

### 6.4.2 gv

**gv** нь PostScript болон PDF үзүүлэгч юм. Энэ нь эхлээд **ghostview** дээр суурилсан боловч **Xaw3d** сангийн тусламжтай илүү сайхан харагдах болсон. Энэ нь хурдан бөгөөд интерфэйс нь цэвэрхэн байдаг. **gv** нь байрлуулалт, цаасны хэмжээ, масштаб эсвэл **antialias** зэрэг олон боломжуудтай байдаг. Бараг бүх үйлдлүүд нь гараас эсвэл хулганаас хийгдэж болно.

**gv**-г багц хэлбэрээр суулгахын тулд доор дурдсаныг хийнэ:

```
# pkg_add -r gv
```

Хэрэв та багцыг авч чадахгүй байгаа бол портын цуглуулгыг ашиглаж болно:

```
# cd /usr/ports/print/gv
# make install clean
```

### 6.4.3 Xpdf

Хэрэв та жижиг FreeBSD PDF үзүүлэгчийг хүсэж байгаа бол **Xpdf** нь хөнгөн бөгөөд үр ашигтай үзүүлэгч юм. Энэ нь маш цөөн эх үүсвэрүүдийг шаарддаг бөгөөд маш тогтвортой ажилладаг. Стандарт X фонтуудыг ашигладаг бөгөөд **Motif** юм уу эсвэл бусад дурын X хэрэгслүүдийг шаарддаггүй.

**Xpdf** багцыг суулгахын тулд энэ тушаалыг ажиллуулна:

```
# pkg_add -r xpdf
```

Багц байхгүй юм уу эсвэл та портын цуглуулга ашиглахыг илүүд үзэж байгаа бол доор дурдсаныг хийнэ:

```
# cd /usr/ports/graphics/xpdf
# make install clean
```

Суулгац дууссаны дараа та **Xpdf**-г ажиллуулж хулганы баруун товчийг ашиглаж цэсийг идэвхжүүлж болно.

### 6.4.4 GQview

**GQview** нь зургийн менежер юм. Та файлыг ганц даралтаар үзэх, гадаад засварлагчийг ажиллуулах, зургийг жижгээр урьдчилан үзүүлэх зэрэг олон зүйлсийг хийж болох юм. Энэ нь бас *slideshow* буюу цомог үзүүлэх горим болон файлын зарим нэг үндсэн үйлдлүүдтэй. Та зургийн цуглуулгуудыг удирдаж давтагдаж байгааг нь хялбархан олж болно. **GQview** нь бүрэн дэлгэцээр үзүүлэх болон интернационалчлалыг дэмждэг.

Хэрэв та **GQview** багцыг суулгахыг хүсэж байгаа бол доор дурдсаныг хийнэ:

```
# pkg_add -r gqview
```

Багц байхгүй юм уу эсвэл та портын цуглуулга ашиглахыг илүүд үзэж байгаа бол доор дурдсаныг хийнэ:

```
# cd /usr/ports/graphics/gqview
# make install clean
```

## 6.5 Санхүү

Хэрэв ямар нэгэн шалтгаанаар та өөрийн хувийн санхүүг FreeBSD ширээний компьютер дээрээ удирдахыг хүсэж байгаа бол хүчирхэг, ашиглахад хялбар, суулгахад бэлэн зарим нэг програмууд байдаг. Тэдгээрийн зарим нэг нь **Quicken®** эсвэл **Excel** баримтуудад хэрэглэгддэгтэй адил төрөл бүрийн файлын хэлбэршилтүүдтэй нийцтэй байдаг.

Энэ хэсэг нь эдгээр програмуудыг авч үзэх болно:

Програмын нэр	Шаардлагатай эх үүсвэрүүд	Портоос суулгах	Гол хамаарлууд
<b>GnuCash</b>	бага	хүнд	<b>GNOME</b>
<b>Gnumeric</b>	бага	хүнд	<b>GNOME</b>
<b>Abacus</b>	бага	хөнгөн	<b>Tcl/Tk</b>
<b>KMyMoney</b>	бага	хүнд	<b>KDE</b>

### 6.5.1 GnuCash

**GnuCash** нь эцсийн хэрэглэгчдэд хэрэглэхэд хялбар, бас хүчирхэг програмуудын боломжийг олгох **GNOME**-ийн чармайлтын нэг хэсэг юм. **GnuCash**-ийн тусламжтай та өөрийн орлого болон зарлагууд, банкны данснууд болон хувьцаануудаа хянаж чадах юм. Энэ нь хялбар интерфэйстэйгээс гадна маш мэргэжлийн програм юм.

**GnuCash** нь ухаалаг регистр, системийн шаталсан бүртгэлүүд, гарын олон хурдасгагчид болон автоматаар гүйцээх аргуудтай байдаг. Энэ нь ганц гүйлгээг хэд хэдэн, илүү дэлгэрэнгүй хэсгүүдэд хувааж чаддаг. **GnuCash** нь **Quicken QIF** файлуудыг импорт хийн нийлүүлж чаддаг. Мөн олон улсын огноо болон мөнгөн тэмдэгтийн хэлбэрүүдтэй ажиллаж бас чаддаг байна.

Өөрийн систем дээрээ **GnuCash**-ийг суулгахын тулд доор дурдсаныг хийнэ:

```
# pkg_add -r gnucash
```

Хэрэв багц байхгүй байгаа бол та портын цуглуулгыг ашиглаж болно:

```
# cd /usr/ports/finance/gnucash
# make install clean
```

### 6.5.2 Gnumeric

**Gnumeric** нь хүснэгттэй ажилладаг програм бөгөөд **GNOME** ширээний орчны хэсэг юм. Энэ нь хэрэглэхэд хялбар, олон дарааллын хувьд автоматаар дүүргэх систем бүхий үүрний хэлбэрийн дагуу хэрэглэгчийн оруулж байгаа зүйлийг автоматаар “таах” боломжтой байдаг. Бас **Excel**, **Lotus 1-2-3**, эсвэл **Quattro Pro** зэрэг хэд хэдэн түгээмэл хэлбэршилтүүдээс файлуудыг импорт хийж чаддаг. **Gnumeric** нь зураг зурах `math/gnuplot` програмын тусламжтай зураг зуралтыг дэмждэг. Бас маш олон тооны цуг бүтээгдсэн функцуудтай бөгөөд тоо, мөнгөн тэмдэгт, огноо, цаг зэрэг олон, бүх энгийн үүрний хэлбэрүүдийг зөвшөөрдөг.

**Gnumeric**-ийг багцаас суулгахын тулд доор дурдсаныг хийнэ:

```
# pkg_add -r gnumeric
```

Хэрэв багц байхгүй бол та доор дурдсаныг хийн портын цуглуулгыг ашиглаж болно:

```
# cd /usr/ports/math/gnumeric
# make install clean
```

### 6.5.3 Abacus

**Abacus** нь жижиг бөгөөд ашиглахад хялбар хүснэгттэй ажиллах програм юм. Энэ нь статистик, санхүү болон математик зэрэг хэд хэдэн салбарт хэрэгтэй, өөрт нь цуг бүтээгдсэн функцуудтай байдаг. Энэ нь **Excel** файлын хэлбэршилтийг импорт, экспорт хийж чаддаг. Мөн **Abacus** нь PostScript гаралтаар гаргаж чаддаг байна.

**Abacus**-ийг багц хэлбэрээр нь суулгахын тулд доор дурдсаныг ажиллуулна:

```
# pkg_add -r abacus
```

Хэрэв багц байхгүй бол та доор дурдсаныг хийн портын цуглуулгыг ашиглаж болно:

```
# cd /usr/ports/deskutils/abacus
# make install clean
```

### 6.5.4 KMyMoney

**KMyMoney** нь **KDE**-д зориулсан хувийн санхүүгийн менежер юм. **KMyMoney** нь арилжааны зорилгоор хийгдсэн хувийн санхүүгийн менежер програмуудад байдаг бүх л чухал боломжуудыг өөртөө агуулсан байдаг. Бас ашиглахад хялбар, дахин оруулах зөв бүртгэлийн систем зэрэг боломжуудыг нь дурдаж болох юм. **KMyMoney** нь стандарт **Quicken Interchange Format (QIF)** бүхий файлуудаас импорт хийж чаддагаас гадна хөрөнгө оруулалтыг хянах, олон төрлийн мөнгөн тэмдэгтүүдтэй ажиллаж чаддаг бөгөөд баялаг тайлангуудыг гаргаж чаддаг. **OFX** импорт хийх боломжууд нь бас тусдаа залгаасын тусламжтай хийгдэж болдог байна.

**KMyMoney**-г багц хэлбэрээс суулгахын тулд дараахийг хийнэ:

```
# pkg_add -r kmyoney2
```

Хэрэв багц байхгүй бол портын цуглуулгаас суулгаж болно:

```
# cd /usr/ports/finance/kmyoney2
# make install clean
```

## 6.6 Дүгнэлт

FreeBSD нь ISP-уудын дунд өөрийн ажиллагаа болон найдвартай байдлаараа алдартай байдаг ч гэсэн түүнийг өдөр тутам ширээний компьютер болгон ашиглахад бараг л бэлэн болжээ. Багцууд (<http://www.FreeBSD.org/where.html>) эсвэл портууд (<http://www.FreeBSD.org/ports/index.html>) хэлбэрээр хэдэн мянган програмуудтай болохоор өөрийн чинь бүх хэрэгцээг хангасан төгс ширээний компьютерийг та бүтээж болох юм.

Энэ бүлэгт авч үзсэн ширээний бүх програмуудын тоймыг энд дурдав:

Програмын нэр	Багцын нэр	Портын нэр
<b>Opera</b>	opera	www/opera
<b>Firefox</b>	firefox	www/firefox
<b>KOffice</b>	koffice-kde3	editors/koffice-kde3
<b>AbiWord</b>	abiword	editors/abiword
<b>GIMP</b>	gimp	graphics/gimp
<b>OpenOffice.org</b>	openoffice	editors/openoffice-1.1
<b>Acrobat Reader</b>	acroread	print/acroread7
<b>gv</b>	gv	print/gv
<b>Xpdf</b>	xpdf	graphics/xpdf
<b>GQview</b>	gqview	graphics/gqview
<b>GnuCash</b>	gnucash	finance/gnucash
<b>Gnumeric</b>	gnumeric	math/gnumeric
<b>Abacus</b>	abacus	deskutils/abacus
<b>KMyMoney</b>	kmymoney2	finance/kmymoney2

# Chapter 7 Мультимедиа

*Засварласан Росс Липперт. Орчуулсан Цагаанхүүгийн Ганболд.*

## 7.1 Ерөнхий агуулга

FreeBSD нь танд өөрийн компьютераас гарах өндөр чанарын гаралтад сэтгэл ханамжтай байх боломжийг олгож төрөл бүрийн дууны картуудыг дэмждэг. Энэ нь аудиоог MPEG Аудио Давхарга 3 (MP3), WAV, болон Ogg Vorbis зэрэг бусад олон хэлбэршилтүүдээр бичлэг хийх болон тоглуулах чадвартай байдаг. FreeBSD-ийн портын цуглуулга нь таны бичигдсэн аудиоог засварлах, дууны нөлөөллүүдийг нэмэх болон залгагдсан MIDI төхөөрөмжүүд хянахыг зөвшөөрөх програмуудыг бас агуулдаг.

Зарим нэг туршилтын тусламжтайгаар FreeBSD нь видео файлууд болон DVD-үүдийг тоглуулахыг дэмжиж чаддаг. Төрөл бүрийн видео зөөвөрлөгчийг кодчилох, хөрвүүлэх, болон тоглуулах програмуудын тоо дууны програмуудын тоотой харьцуулах юм бол хязгаарлагдмал байдаг. Жишээ нь, үүнийг бичиж байх үед, `audio/sox`-той адил хэлбэршилтүүдийн хооронд хөрвүүлэхэд хэрэглэгдэх дахин кодчилох сайн програм FreeBSD-ийн портын цуглуулгад байхгүй байгаа билээ. Гэхдээ энэ талбар дахь програм хангамжийн байдал хурдацтай өөрчлөгдөж байна.

Энэ бүлэг нь таны дууны картыг тохируулахад шаардлагатай алхмуудыг тайлбарлах болно. X11-ийн (Chapter 5) тохиргоо болон суулгац нь таны видео тоног төхөөрөмжийн асуудлуудыг аль хэдийн зохицуулсан байдаг боловч илүү сайн тоглуулахын тулд зарим нэгэн нарийн тохируулгууд хийх хэрэгтэй байж болох юм.

Энэ бүлгийг уншиж дууссаны дараа та дараах зүйлсийг мэдэх болно:

- Таны дууны карт чинь танигдсан байхаар өөрийн системээ хэрхэн тохируулах талаар.
- Таны карт ажиллаж байгааг шалгах аргууд.
- Өөрийн дууны тохиргооны алдааг хэрхэн олж засварлах талаар.
- MP3-ууд болон бусад аудиоог хэрхэн тоглуулах ба кодчилох талаар.
- X серверээр видео хэрхэн дэмжигдсэн талаар.
- Сайн үр дүн өгдөг зарим нэгэн тоглуулагч/кодчилогч портууд.
- DVD-үүд, `.mpeg` болон `.avi` файлуудыг хэрхэн тоглуулах талаар.
- CD болон DVD-ээс файлууд уруу агуулгыг хэрхэн авах талаар.
- TV карт хэрхэн тохируулах талаар.
- Дүрс скан хийгчийг хэрхэн тохируулах талаар.

Энэ бүлгийг уншихаасаа өмнө, та дараах зүйлсийг мэдэх шаардлагатай:

- Шинэ цөмийг хэрхэн тохируулж суулгах талаар мэдэх (Chapter 8).

**Warning:** `mount(8)` тушаалаар аудио CD-үүдийг холбохыг оролдох нь хамгийн гайгүйдээ алдаанд, хамгийн муудаа *цөмийн сүйрэлд* хүргэж болох юм. Эдгээр зөөвөрлөгчид нь ердийн ISO файлын системүүдээс ялгаатай тусгай кодчилуудтай байдаг.

## 7.2 Дууны картыг тохируулах

*Хувь нэмэр болгон оруулсан Мозес Мур. FreeBSD 5.X-д зориулж өргөжүүлсэн Марк Фонвил.*

### 7.2.1 Системийг тохируулах

Эхлэхээсээ өмнө та өөртөө байгаа картыхаа загвар, ашиглаж байгаа бичил схем болон PCI эсвэл ISA картны алин болохыг мэдэх шаардлагатай. FreeBSD нь төрөл бүрийн PCI эсвэл ISA картуудыг дэмждэг. Тоног төхөөрөмжийн тэмдэглэгээ (<http://www.FreeBSD.org/releases/8.0R/hardware.html>)ний дэмжигдсэн аудио төхөөрөмжүүдийн жагсаалтыг шалгаж өөрийн картыг дэмжигдсэн эсэхийг үзээрэй. Тоног төхөөрөмжийн тэмдэглэгээ нь таны картыг ямар драйвер дэмждэгийг бас хэлэх болно.

Өөрийн дууны төхөөрөмжийг ашиглахын тулд тохирох төхөөрөмжийн драйверийг та ачаалах хэрэгтэй болно. Үүнийг хоёр аргын аль нэгээр хийж болно. Хамгийн амархан арга бол `kldload(8)` тушаалаар өөрийн картныхаа цөмийн модулийг тушаалын мөрөөс:

```
# kldload snd_emu10k1
```

гэж ачаалах юм уу эсвэл `/boot/loader.conf` файлд тохирох мөрийг ингэж нэмэн дуудаж болно:

```
snd_emu10k1_load="YES"
```

Эдгээр жишээнүүд нь Creative SoundBlaster® Live! дууны картанд зориулагдсан юм. Бусад байгаа дуудагдаж болох дууны модулиуд `/boot/defaults/loader.conf`-д жагсаагдсан байдаг. Хэрэв та аль драйверийг ашиглахаа мэдэхгүй эргэлзэж байвал `snd_driver` модулийг дуудаж үзэж болох юм:

```
# kldload snd_driver
```

Энэ нь хамгийн түгээмэл драйверуудыг нэг удаа ачаалдаг метадрайвер юм. Энэ нь зөв драйверийг хайхыг хурдасгадаг. Дууны бүх драйверуудыг `/boot/loader.conf` файлаар ачаалах бас боломжтой байдаг.

`snd_driver` метадрайверийг дуудсаны дараа та өөрийн дууны картдаа ямар драйвер сонгогдсоныг олохыг хүсвэл `/dev/sndstat` файлыг `cat /dev/sndstat` тушаалын тусламжтай шалгаж болох юм.

Хоёр дахь арга нь өөрийн дууны картын дэмжлэгийг өөрийн цөмдөө эмхэтгэх явдал юм. Доорх хэсэг нь энэ аргаар өөрийн тоног төхөөрөмжид зориулан дэмжлэг нэмэхэд шаардлагатай мэдээллийг өгнө. Өөрийн цөмийг дахин эмхэтгэх тухай дэлгэрэнгүй мэдээллийг Chapter 8-с үзнэ үү.

#### 7.2.1.1 Дууны дэмжлэгтэй цөмийг тохируулах

Эхлээд хийх ёстой зүйл нь аудио тогтолцооны драйвер `sound(4)`-г цөм уруу нэмэх явдал юм. Ингэхийн тулд та дараах мөрийг цөмийн тохиргооны файлдаа нэмэх хэрэгтэй болно:

```
device sound
```

